



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН
СТАТИСТИКИЙН
МЭДЭЭЛЭЛ
2018 ОН**

Агуулга

Агуулга	2
Өмнөх үг.....	3
1. Өрсөлдөх чадвар.....	4
2. Үндсэн үзүүлэлт.....	5
2.1 Зорчигч тээвэрлэлт.....	6
2.2 Зорчигч болон ачаа тээвэрлэлт.....	7
2.3 Ачаа тээвэрлэлт.....	8
2.4 Хөдөлмөр эрхлэлт	9
3. Авто замын салбарын үндсэн үзүүлэлт	10
4. Автотээврийн салбарын үндсэн үзүүлэлт	14
5. Төмөр замын тээврийн салбарын үндсэн үзүүлэлт	19
6. Агаарын тээврийн салбарын үндсэн үзүүлэлт	23
7. Усан зам, далайн тээврийн салбарын үндсэн үзүүлэлт	28
8. Зам, тээврийн ослын талаарх мэдээлэл.....	31
9. Дүгнэлт.....	34
10. Хавсралт	35
11. Үгийн тайлбар.....	39

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Статистикийн тухай хуульд статистикийн мэдээлэл нь албан ёсны болон захиргааны гэсэн 2 хэлбэртэй байхаар заасан байдаг.

Үндэсний статистикийн хорооноос баталж, зөвшөөрсөн аргачлал, үзүүлэлтээр зам, тээврийн салбарын албан ёсны статистик мэдээллийг Монгол Улсын эдийн засаг, хүн ам, нийгэм, байгаль орчны холбогдолтой үзүүлэлт болон статистикийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мэдээллийг Статистикийн тухай хуулиар заасан хугацаанд нэгтгэн хүргүүлж байгаа билээ.

Мөн түүнчлэн Зам, тээврийн хөгжлийн яам, түүний харьяа агентлаг, үйлдвэрийн газар, байгууллагын хэрэгцээнд зориулан захиргааны мэдээллийг эмхтгэн гаргахаар зорин ажиллалаа.

Статистикийн мэдээллийг эмхтгэн боловсруулахдаа зам, тээврийн салбарын нэгдсэн бодлого болон дэд салбарын бодлого боловсруулах, төлөвлөх, богино, дунд болон урт хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхэд ашиглах зорилгоор шинжлэх ухааны үндэслэл бүхий, аль болохоор ойлгомжтой, ашиглахад дөхөм байлгах үүднээс Үндэсний статистикийн хороо, Зам, тээврийн хөгжлийн яамны газар, хэлтэс болон Иргэний нисэхийн ерөнхий газар, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах нэгдсэн төв, Авто тээврийн үндэсний төв, Улаанбаатар төмөр зам, Далайн захиргаа зэрэг харьяа газруудын 2018 оны тайлан, мэдээллийг 2017 оны тайлан, мэдээлэлтэй харьцуулан инфографикаар харуулсан болно.

Энэхүү статистикийн мэдээллийг олон улсын стандарт, хэм хэмжээнд нийцүүлэх, үе шаттайгаар сайжруулах, мэдээллийн хүрээг өргөжүүлэн жил бүр цуврал болгон гаргаж байхаар зорин ажиллаж байна. Гэхдээ ямар нэг алдаа, ташаа зүйл байвал залруулан тусална гэдэгт найдаж байна.

Тус статистикийн мэдээллийг нэгтгэн гаргах талаар үнэтэй үүрэг, чиглэл өгч зааварлан ажилласан Зам, тээврийн хөгжлийн Сайд, Дэд сайд болон яамны бусад удирдлага, мөн бэлтгэн боловсруулахад оролцож дэмжсэн, хэвлэн нийтлэхэд чин сэтгэлээс тусалсан Ган Зам хэвлэх үйлдвэрийн дарга, хамт олонд гүнээ талархахын ялдамд цаашдын ажил үйлсийнх нь алтан шар зам өөдрөг байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

1. ӨРСӨЛДӨХ ЧАДВАР *

Дэлхийн эдийн засгийн форумас тооцдог өрсөлдөх чадварын судалгаагаар 2018 онд **Монгол Улс 140** орноос **99**-р байранд орсон байна.



Дэд бүтцийн хөгжлөөрөө **103**-р байранд жагссан байна.

Үүнд:

- Замын индекс 105-р байр
- Замын чанар 110-р байр
- Төмөр замын тээвэрлэлт 94-р байр
- Галт тэрэгний үйлчилгээ 62-р байр
- Нисэх буудал 97-р байр
- Агаарын тээврийн үйлчилгээ 113-р байр
- Далайн тээвэрлэлт 137-р байр

* Дэлхийн өрсөлдөх чадварын 2018 оны тайлан судалгаа

2. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ *

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он	2018 он
Зам				
Сайжруулсан авто замын нийт урт, км **	9 812,1	10 126,0	10 355,2	10 835,8
Үүнээс: Хатуу хучилттай, км	7 125,3	7 456,6	8 431,4	9 022,7
Хайрган хучилттай, км	1 715,6	1 696,8	1 308,9	1 207,9
Сайжруулсан хөрсөн зам, км	971,2	972,6	614,9	604,9
Гүүрийн урт, у/м**	-	34 410,2	35 251,0	35 318,4
Төмөр замын нийт урт, км***	1 815,0	1 815,0	1 815,0	1 920,0
Агаарын тээврийн замын тоо ****	-	-	62	62
Авто тээвэр				
Зорчигчдын тоо, сая хүн	256,5	260,7	212,2	196,9
Зорчигч эргэлт, сая хүн.км	1 940,5	1 959,9	2 040,9	2 125,7
Тээвэрлэсэн ачаа, мян.тн	13 043,7	20 406,2	31 212,9	44 138,9
Ачаа эргэлт, сая тн.км	2 374,0	4 236,2	5 661,3	6 744,9
Тээврийн орлого, тэрбум төгрөг	345,1	467,2	506,4	627,83
Тээврийн хэрэгслийн тоо, ш *****	789 720	841 552	900 145	970 846
Агаарын тээвэр				
Зорчигчдын тоо, сая хүн****	0,9	1,0	1,2	1,42
Зорчигч эргэлт, сая хүн.км	1 123,3	1 156,5	1 363,2	1 573,5
Тээвэрлэсэн ачаа, мян.тн****	4,7	4,8	5,3	5,7
Ачаа эргэлт, сая тн.км	7,7	8,1	7,8	7,8
Тээврийн орлого, тэрбум төгрөг	254,3	287,3	385,5	442,2
Төмөр замын тээвэр***				
Зорчигчдын тоо, сая хүн	2,79	2,64	2,63	2,57
Зорчигч эргэлт, сая хүн.км	996,7	955,5	973,2	993,7
Тээвэрлэсэн ачаа, мян.тн	19 150,8	19 989,1	22 765,0	25 763,3
Ачаа эргэлт, сая тн.км	11 462,6	12 371,0	13 493,3	15 315,3
Тээврийн орлого, тэрбум төгрөг	387,9	441,8	530,0	616,48
Усан замын тээвэр*****				
Зорчигчдын тоо, сая хүн	0,05	0,03	0,02	0,02
Зорчигч эргэлт, сая хүн.км	0,9	0,68	0,4	0,4
Тээвэрлэсэн ачаа, мян.тн	-	-	-	-
Тээврийн орлого, тэрбум төгрөг	0,58	0,23	0,30	0,5

*ҮСХ-ны мэдээллийн эх үүсвэр

**АЗБХЗГ-ын мэдээлэл


***ТЗДТБХЗГ-ын мэдээлэл

****ИНЕГ-ын мэдээлэл

*****“АТҮТ” ТӨҮГ-ын VRS автотээврийн хэрэгслийн бүртгэлийн системийн мэдээлэл

*****МУ-ын Далайн Захиргааны мэдээлэл

2.1. ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ



2.2. ЗОРЧИГЧ БОЛОН АЧАА ТЭЭВЭРЛЭЛТ

Зам, тээврийн салбар 2018 онд бүх төрлийн тээврээр тээвэрлэсэн нийт ачаа 69,8 сая тонн, зорчигчид давхардсан тоогоор 200,9 сая хүн болж, өмнөх оноос тээвэрлэсэн ачаа 15,9 сая тонн буюу 29,4%-иар өсөж, зорчигч 15,19 сая хүн буюу 7%-иар буурсан байна.

Зорчигч тээвэр: 2018 онд тээвэрлэсэн нийт зорчигчийн 98%-ийг автотээврээр тээвэрлэсэн байна. /График 1/

- Авто тээврээр 2018 онд давхардсан тоогоор 196,9 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оноос зорчигчид 15,3 сая хүн буюу 7,2%-иар буурсан байна.
- Төмөр замын тээврээр 2018 онд зорчигчид давхардсан тоогоор 2,6 сая хүн болж, өмнөх оноос зорчигчид 64,4 мянган хүн буюу 2,3%-иар буурсан байна.
- Агаарын тээврээр 2018 онд зорчигчид 1,42 сая хүн болж, өмнөх оноос зорчигчид 0,17 сая хүн буюу 13.6%-иар өсжээ.
- Усан замын тээврээр 2018 онд 25,6 мянган хүн тээвэрлэсэн нь өмнөх оныхоос зорчигчийн тоо 5 082 хүн буюу 24,7%-иар өссөн байна.




График 1. Зорчигч тээвэр, сая хүн

Ачаа тээвэр: Нийт ачаа тээврийн 63,18%-ийг автотээврээр, 36,81%-ийг төмөр замын тээврээр, 0,01%-ийг агаарын тээврээр тээвэрлэсэн байна. /График 2/

- Автотээврээр 2018 онд 44,1 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оноос тээвэрлэсэн ачаа 12,9 сая тонн буюу 41,4%-иар өссөн байна.
- Төмөр замаар тээвэрлэсэн нийт ачаанд дотоодын ачаа 2018 онд өмнөх оноос экспортын ачааных 1,4 пункт, импортын ачааных 1,0 пунктээр өсөж, харин дотоодын ачааных 1,9 пункт, дамжин өнгөрсөн ачааных 0,5 пунктээр буурсан байна.
- Агаарын тээврээр тээвэрлэсэн ачаа 2018 онд 5,75 мянган тонн болж, өмнөх оноос тээвэрлэсэн ачаа 383 тонн буюу 7,8%-иар өсжээ.




График 2. Ачаа тээвэр, мян.тн

2.3. АЧАА ТЭЭВЭРЛЭЛТ

5,75

МЯНГАН ТОНН

Өмнөх оноос
7,8% ↑



- Олон улс- 5 644 тн;
- Орон нутаг- 108 тн;

44,1

САЯ ТОНН

Өмнөх оноос
41,4% ↑



25,7

САЯ ТОНН

Өмнөх оноос
12,9% ↑

- Орон нутгийн- 10 326,8 мян.тн;
- Экспорт- 9 272,4 мян.тн;
- Дамжин өнгөрөлт- 3 365,7 мян.тн;
- Импорт- 2 798,4 мян.тн;



Нийт **69,8** САЯ ТОНН

ачаа тээвэрлэсэн нь

өмнөх оноос 29,4% ↑

НИЙТ АЧАА ТЭЭВЭРЛЭЛТ:



- Автотээвэр- 63,18%
- Төмөр замын тээвэр- 36,81%
- Агаарын тээвэр- 0,01%

2.4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН
ХЭМЖЭЭНД НИЙТ

41 616

ХҮН АЖИЛЛАЖ БАЙНА.



42%
ЭМЭГТЭЙ АЖИЛЧИД

58%
ЭРЭГТЭЙ АЖИЛЧИД

3. АВТО ЗАМЫН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ*

Монгол Улсын Авто замын тухай хуулийн 4.1.22, 14.1**–т заасны дагуу Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үндэсний авто замын сүлжээ нь олон улс, улс, нийслэл, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто замаас бүрдэнэ. Үндэсний авто замын сүлжээний нийт урт 2018 оны жилийн эцсээр 111 916,7 км байгаагийн 101 081,18 км нь буюу 90,3% нь ердийн хөрсөн, 10 835,52 км буюу 9,7% нь сайжруулсан зам байна. /График 3/

Монгол Улсын 1000 км хавтгай дөрвөлжин,(км.кв) нутаг дэвсгэрт 2018 оны жилийн эцсийн байдлаар 6.9 км сайжруулсан зам ногдож байгаа нь өмнөх оныхоос 4,6%-иар өссөн байна.

Нийт сайжруулсан замын 9 022.7 км буюу 83,3%-ийг хатуу хучилттай, 1 207.9 км буюу 11,1%-ийг хайрган хучилттай, 604.9 км буюу 5,6%-ийг сайжруулсан хөрсөн зам эзэлж байна. /График 3/




График 3. Монгол Улсын үндэсний авто замын сүлжээ

Монгол Улсын авто замын нийт сүлжээнд олон улсын болон улсын чанартай зам 14 918,7 км буюу 13,3%, орон нутгийн чанартай зам 96 125,3 км буюу 85,9%, уул уурхайн буюу тусгай зориулалттай зам 872,7 км буюу 0,8%-ийг эзэлж байна /Хүснэгт 1/.

Хатуу хучилттай зам 2018 онд нийт 9 022,7 км болж өмнөх оныхоос 591,6 км буюу 7%-иар өсч, харин хайрган хучилттай зам 101 км буюу 7,7%-иар, сайжруулсан хөрсөн зам 10 км буюу 1,6%-иар багасчээ. /График 4/

* АЗБХЗГ-ын мэдээлэл

** Авто замын тухай шинэчилэн батлагдсан хууль, 2017




График 4. Сайжруулсан авто зам, км




График 5. Хатуу хучилттай авто замын бүтэц

Хатуу хучилттай замын 6 718,1 км буюу 74% нь улсын, 1 431,9 км буюу 16% нь орон нутгийн, 872,7 км буюу 10% нь уул уурхайн (тусгай) зориулалттай зам байна. /График 5/

Хатуу хучилттай авто замыг хучилтын төрлөөр авч үзвэл 8 706,4 км буюу 97%-ийг асфальт бетон, 205,2 км буюу 2%-ийг хөнгөвчилсэн хучилттай, харин цемент бетон зам 116,16 км буюу 1%-ийг эзэлж байна. /График 6/




График 6. Хатуу хучилттай авто замын хучилтын төрөл



График 7. Хатуу хучилттай авто зам, км

Асфальт бетон зам 2018 онд 8 706,4 км болсон нь өмнөх оныхоос 418,3 км буюу 5%-иар нэмэгдсэн. Харин хөнгөвчилсэн хучилттай болон цемент бетон замын хэмжээ нь өмнөх оныхоос өөрчлөгдөөгүй байна. /График 7/

Хүснэгт 1.

Үндэсний авто замын сүлжээ

Авто замын төрөл	Хэмжих нэгж	Бүгд	Үүнээс		
			Улсын чанартай	Орон нутгийн чанартай	Уул уурхайн зориулалттай зам
Авто замын сүлжээний нийт урт	км	111 916,7	14 918,7	9 6125,3	872,7
Үүнээс:					
1. Хатуу хучилттай	км	9 023	6 718	1 431,93	872,7
а. Цемент бетон	км	111,16	36,50	31,46	43,2
б. Асфальт бетон	км	8 706,4	6 476,4	1 400,47	829,5
в. Хөнгөвчилсэн	км	205,2	205,2	-	-
2. Хайрган хучилттай	км	1 207,89	923,56	284,33	-
3. Сайжруулсан хөрсөн	км	604,9	211,9	393	-
4. Ердийн хөрсөн зам	км	101 081,18	7 065,1	9 4016,04	-

Гүүр. Улсын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар 35 318,4 метр урттай 712 гүүр байгаагийн 441 гүүр буюу 61,9% нь төмөр бетон, 263 гүүр буюу 36,9% нь модон, 8 буюу 1,1% нь ган хийцтэй гүүр байна. /Хүснэгт 2, График 8/

Хүснэгт 2.

Гүүрийн тоо, хэмжээ

Он	2016	2017	2018	%
Гүүрийн тоо, ш				
Нийт	706	710	712	100
Төмөр бетон	435	439	441	61,94
Модон	263	263	263	36,94
Ган	8	8	8	1,12
Гүүрийн хэмжээ, у.м				
Нийт	34 410,15	35 251,0	35 318,4	100
Төмөр бетон	24 098,3	24 939,1	25 006,5	70,8
Модон	8 637,9	8 637,9	8 637,9	4,7
Ган	1 674,0	1 674,0	1 674,0	24,5




График 8. Гүүрийн хэмжээ, у.м

2018 онд гүүрийн тоо өмнөх оныхоос 2 гүүр буюу 0,3%-иар, уртын хэмжээ 67,4 у.м буюу 0,2%-иар өссөн бөгөөд энэхүү 2 гүүр нь төмөр бетон хийцтэй юм. /Хүснэгт 2/

4. АВТОТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ*

Автотээврийн салбар 2018 онд давхардсан тоогоор 196,9 сая хүн зорчигч тээвэрлэж, зорчигч эргэлт 2 125,7 сая хүн.км болж, өмнөх оныхоос зорчигчийн тоо 15,3 сая хүн буюу 7,3%-иар буурч, зорчигч эргэлт 84,8 сая хүн.км буюу 4,2%-иар өссөн байна. /График 9/




График 9. Автотээврээр зорчсон зорчигч, сая хүн

Автотээврээр 2018 онд 44 138,9 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оныхоос 12 926 мян.тн буюу 41,4%-иар өсжээ. /График 10/

Автотээврийн ачаа эргэлт 2018 онд 6 744,9 сая тн.км болж, өмнөх оныхоос 1 083,6 сая тн.км буюу 19%-иар өссөн байна.




График 10. Автотээврээр тээвэрлэсэн ачаа, мян.тн

Тээврийн хэрэгслийн тоо, 2018 он**.




График 11. Тээврийн хэрэгслийн төрөл, хувиар

Монгол Улсын тээврийн хэрэгслийн бүртгэлийн санд бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн тоо 2018 онд нийт 970 818 болж өмнөх оныхоос 70 693 тээврийн хэрэгсэл буюу 7,8%-иар өссөн байна. Үүнээс 871 329 буюу 89,7%-ийг автомашин, 5,8%-ийг мотоцикл, 3,2%-ийг чиргүүл, 1,3%-ийг механизм тус тус эзэлж байна. /График 11/

* ҮСХ-ны мэдээллийн эх үүсвэр

** "АТҮТ" ТӨҮГ-ын VRS автотээврийн хэрэгслийн бүртгэлийн системийн мэдээлэл

Нийт тээврийн хэрэгслийн 789 204 буюу 81,3% нь 10-аас дээш жил, 154 996 буюу 16% нь 4-9 жил , 26 618 буюу 2,7% нь 0-3 жилийн насжилттай байна. /График 12/




График 12. Тээврийн хэрэгслийн насжилт

4-6 жилийн насжилттай тээврийн хэрэгсэл өмнөх оныхоос 5 128 буюу 12%-иар буурч, 0-3 жилийн насжилттай тээврийн хэрэгсэл 7 778 буюу 41,3%, 7-9 жилийн насжилттай тээврийн хэрэгсэл 23 898 буюу 25,6%, 10 болон түүнээс дээш жилийн насжилттай тээврийн хэрэгсэл 3 944 буюу 0,5%-иар тус тус өссөн байна. /График 12/

Нийт 871 329 автомашиныг зориулалтаар авч үзвэл, 631 421 буюу 72,5% нь суудлын, 190 406 буюу 21,9% нь ачааны, 6 501 буюу 0,7% нь автобус, 14 686 буюу 1,7% нь тусгай зориулалтын автомашин, 6 781 буюу 0,8% нь цистерн, 21 534 буюу 2,5% нь зүтгүүр байна. /График 13/




График 13. Автомашины зориулалт




График 14. Автомашины жолооны хүрдний байрлал

2018 онд нийт 871 329 автомашин бүртгэлтэй байгаагаас 407 391 буюу 46,8% нь зүүн талдаа жолооны хүрдтэй, 463 938 буюу 53,2% нь баруун талдаа жолооны хүрдтэй байна. Баруун талдаа жолооны хүрдтэй автомашины тоо өмнөх оныхоос

13,1%-иар, зүүн талдаа жолооны хүрдтэй автомашины тоо 0,7%-иар тус тус өссөн байна. /График 14/





График 15. Шинээр бүртгэгдсэн автомашины жолооны хүрдний байрлал, тоо

2018 онд шинээр 84 034 автомашин бүртгэгдсэнээс баруун талдаа жолооны хүрдтэй автомашины тоо 58 713 болсон нь өмнөх оныхоос 30,3%-иар, зүүн талдаа жолооны хүрдтэй автомашины тоо 25 321 болсон нь өмнөх оныхоос 34,8%-иар тус тус өссөн байна. /График 15/*



Хөдөлгүүрийн багтаамж	Автомашины тоо	Эзлэх хувь
		871 329
1500 см³ хүртэл	285 533	32,8%
1501-2500 см³	331 422	38,0%
2501-3500 см³	123 379	14,2%
3501-4500 см³	36 448	4,2%
4501 см³ дээш	94 547	10,9%

График 16. Автомашины хөдөлгүүрийн багтаамж

Нийт автомашины 38% нь 1501-2500 см³, 32,8% нь 1501 см³ хүртэл, 14,1% нь 2501-3500 см³, 10,9% нь 4501 см³ дээш, 4,2% нь 3501-4500 см³ хөдөлгүүрийн багтаамжтай байна. /График 16/

Нийт автомашины 450 949 буюу 51,75% нь бензин, 238 383 буюу 27,36% нь дизель, 161 426 буюу 18,53% нь хосолсон, 20 398 буюу 2,34% нь газ, 173 буюу 0,02% нь цахилгаанаар ажилладаг хөдөлгүүр бүхий автомашин байна. /График 17/

* “АТҮТ” ТӨҮГ-ын VRS автотээврийн хэрэгслийн бүртгэлийн системийн мэдээлэл




График 17. Автомашины хөдөлгүүрийн төрөл, хувиар

2018 онд хосолсон хөдөлгүүртэй автомашин өмнөх оныхоос 35 079 буюу 27,8%-иар, газын хөдөлгүүртэй автомашин 2 564 буюу 14,4%-иар, цахилгаан хөдөлгүүртэй автомашин 87 буюу 101,2%-иар, дизель хөдөлгүүртэй автомашин 13 929 буюу 6,2%-иар, бензин хөдөлгүүртэй автомашин 4 659 буюу 1%-иар тус тус өссөн байна.

Улаанбаатар хотод бүртгэлтэй автомашины тоо 501 925 буюу нийт автомашины 57,6%-ийг эзэлж байна. 2018 онд Улаанбаатар хотод бүртгэлтэй автомашины тоо өмнөх оныхоос 1,4%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Бүх аймгийн тээврийн хэрэгслийн тоог харьцуулж үзэхэд Өмнөговь аймагт 38 971 буюу 4% ногдож буй нь хамгийн их, Говьсүмбэр аймагт 4 026 буюу 0,4% ногдож байгаа нь хамгийн бага үзүүлэлт болж байна. /График 18/




График 18. Бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо, аймгаар

2018 онд Монгол Улсад бүртгэлтэй нийт 970 818 тээврийн хэрэгслээс техникийн хяналтын үзлэгт 634 669 буюу нийт тээврийн хэрэгслийн 65,3 хувь нь хамрагдсан байна.

Импортоор орж ирсэн тээврийн хэрэгслийн тоо 86 811 болсон нь өмнөх оныхоос 23 278 буюу 36,6%-иар өссөн үзүүлэлттэй байна. /График 19/*




График 19. Импортоор орж ирсэн автотээврийн хэрэгслийн өсөлт, бууралт

2018 онд автотээврийн салбарын нийт орлого 627,8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 121,4 тэрбум төгрөг буюу 24%-иар өссөн байна. /График 20/




График 20. Автотээврийн орлого, тэрбум төгрөг

* Гаалийн ерөнхий газрын 2018 оны статистик мэдээлэл

5. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Улсын хэмжээнд 2018 оны байдлаар нийт 1 920 км урт төмөр зам байгаа нь нэг мянган км хавтгай дөрвөлжин (кв.км) нутаг дэвсгэрт ногдох төмөр зам 1,22 км байна. Монгол Улсад бүртгэлтэй 7 130 ачааны вагон, 187 зүтгүүр төмөр замын хөдөлгөөнд оролцож байна.

2018 онд Төмөр замын тээврээр 2 572,5 мян.хүн зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оныхоос 57,8 мян.хүн буюу 2,2%-иар буурчээ. Нийт зорчигчдын 2 454,3 мян.хүн буюу 95,4% нь орон нутагт, 118,2 мян.хүн буюу 4,6% нь олон улсад зорчсон байна. Олон улсын зорчигчийн тоо өмнөх оныхоос 0,6%-иар өсч, орон нутгийн зорчигчийн тоо 0,6%-иар буурсан байна. /График 19/

Төмөр замын зорчигч эргэлт 2018 онд 993,7 сая хүн.км болж өмнөх оноос 20,5 сая хүн.км буюу 2,11%-иар өсжээ.




График 19. Төмөр замын тээврээр зорчсон зорчигчдын тоо, мян.хүн

Төмөр замын тээврээр 25 763,3 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оныхоос 2 998,3 мян.тн буюу 13,2%-иар өссөн байна. Төмөр замын тээврээр тээвэрлэсэн олон улсын ачаа 59,9%, орон нутгийн ачаа 40,1%-ийг тус тус эзэлж байна. /График 20/





График 20. Төмөр замын тээврээр тээсэн ачаа, мян.тн



Төмөр замын тээврээр тээвэрлэсэн олон улсын нийт ачааны 9 272,4 мян.тн буюу 60,1%-ийг экспорт, 2 798,4 мян.тн буюу 18,1%-ийг импорт, 3 365,7 мян.тн буюу 21,8%-ийг дамжин өнгөрөх тээвэрлэлт эзэлж байна. /График 21/

График 21. Төмөр замын тээврээр тээсэн олон улсын ачааны бүтэц




График 22. Төмөр замын тээврээр тээсэн ачаа, ачааны нэр төрөл

Төмөр замын тээврээр тээвэрлэсэн ачааг нэр төрлөөр нь авч үзвэл 8 796,52 мян.тн буюу 45,1% нь нүүрс, 7 106,58 мян.тн буюу 36,5% нь уул уурхайн бүтээгдэхүүн, 1 617,89 мян.тн буюу 8,3% барилгын материал, 617,74 мян.тн буюу 3,2% нь нефть, нефтийн бүтээгдэхүүн, 261,5 мян.тн буюу 1,3% ХАА-н гаралтай бүтээгдэхүүн, 199,56 мян.тн буюу 1% нь хүнсний бүтээгдэхүүн, 184,92 мян.тн буюу 0,9% нь хар төмөр, 111,93 мян.тн буюу 0,6% мод, модон материал, 26,92 мян.тн буюу 0,1% нь түргэн муудах бүтээгдэхүүн, 28,84 мян.тн буюу 0,1% нь үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, 534,81 мян.тн буюу 2,7% нь бусад ачаа тус тус эзэлж байна. /График 22/

Төмөр замын тээврийн ачаа эргэлт 15 315,3 сая тн.км болж, өмнөх оныхоос 1 822 сая тн.км буюу 13,5%-иар өссөн байна. Үүнээс 2 866,3 сая тн.км буюу 18,7% нь орон нутаг, 7 307,3 сая тн.км буюу 47,7% нь экспорт, 1 405,8 сая тн.км буюу 9,2% нь импорт, 3 736 сая тн.км буюу 24,4% нь дамжин өнгөрөх тээврийн ачаа эргэлт эзэлж байна. /График 23/




График 23. Төмөр замын тээврийн ачаа эргэлт, сая тн.км

Төмөр замын тээврийн орлого 2018 онд 616,475 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 86,459 тэрбум төгрөг буюу 16,3%-иар өссөн байна. /График 24/






График 24. Төмөр замын тээврийн орлого, тэрбум төгрөг

Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт



Ачилт-ачааны нэр төрлөөр



* “УБТЗ” ХНН-ийн 2018 оны тайлан мэдээ

6. АГААРЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Улсын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар агаарын тээврийн 62 зам бүртгэгдсэнээс бүсийн навигацийн маршрут 10, дээд агаарын зам 37, доод агаарын зам 45 тус тус байна. Дээд, доод агаарын зам нь давхцдаг ба уламжлалт маршрут нь 52 байгаа юм.

Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийн тоо 34 байгаагаас 2018 онд нислэгт тэнцэх чадварын хүчин төгөлдөр гэрчилгээтэй агаарын хөлгийн тоо 15 байна.

Агаарын тээврийн салбар 2018 онд нийт 1 422,49 мян.хүн зорчигч тээвэрлэж өмнөх оныхоос 170,7 мян.хүн буюу 13,6%-иар өссөн байна.

Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо орон нутагт 401,6 мян.хүн болж өмнөх оныхоос 76,57 мян.хүн зорчигч буюу 23,5%, олон улсад 1 020,89 мян.хүн болж өмнөх оныхоос 94,15 мян.хүн буюу 10,16%-иар өссөн байна. /График 25/




График 25. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо

Агаарын тээврээр 2018 онд нийт ачаа 5 752 тн тээвэрлэсэн нь өмнөх оныхоос 383 тн буюу 7,1%-иар өссөн байна. Нийт тээвэрлэсэн ачаанаас олон улсад 5 644 тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оныхоос 428 тн буюу 8,2%-иар өсч, орон нутагт 108 тн ачаа тээвэрлэсэн нь 45 тн буюу 29,4%-иар буурсан үзүүлэлттэй байна. /График 26/





График 26. Агаарын тээврээр тээвэрлэсэн ачаа, тонн



Агаарын тээврийн ачааг шуудан, тээш, ачаа гэж 3 ангилан авч үздэг ба 2018 онд агаарын тээврээр тээвэрлэсэн нийт ачааны 5 339 тн буюу 92,8%-ийг ачаа, 413 тн буюу 7,2%-ийг шуудан эзэлж байна. /График 27/

График 27. Агаарын тээврээр тээвэрлэсэн ачааны төрөл, тн




График 28. Орон нутгийн зорчигч тээвэрлэлт

2018 онд орон нутагт зорчигчдын тоо 401,6 мян.хүн болж, үүнээс зөвхөн уул уурхайн захиалгат нислэг Оюутолгой, Оюутолгой-Даланзадгад, Овоот чиглэлд

зорчигчийн тоо 293,43 мян.хүн буюу 73%, орон нутгийн хуваарьт нислэгээр 106,15 мян.хүн буюу 26%, захиалгат нислэгээр 202,9 мян.хүн буюу орон нутгийн нислэгийн 1%-ийг тус тус эзэлж байна. /График 28/

Хүснэгт 3.

Олон улсын зорчигч тээвэрлэлт, тээвэрлэгч тус бүрээр

Агаарын тээвэрлэгч	Чиглэл	2017 он	2018 он
МИАТ ХК	Бээжин	101 663	108 723
	Сөүл	153 159	172 768
	Хонг конг	60 236	69 937
	Токио	61 854	69 795
	Москва	14 609	19 097
	Берлин	15 902	14 910
	Москва-Берлин	10 212	8 367
	Бусан	9 310	18 371
	Бангкок	3 145	13 019
	Франкфурт	9 335	9 929
	Захиалгат	10 751	9 693
Нийт		450 176	514 609
Хүннү Эйр ХХК	Манжуур	14 499	13 629
	Улаан-Үүд	1 867	4 661
	Эрээн	20 779	18 938
	Бугат	7 646	3 848
	Хайлаар	1 226	2 969
Нийт		46 017	44 045
Аэромонголиа ХХК	Хөх хот	11 309	11 609
	Эрхүү	12 028	12 718
	Улаан-Үүд		311
Нийт		23 337	24 638
Эйр Чайна	Бээжин	99 516	101 777
Кореан Эйр	Сөүл	182 979	188 571
Аэрофлот	Москва	52 809	55 119
Туркиш Эйрлайнс	Бишкек- Истанбул	39 083	42 058
Эйр Бусан	Бусан	28 029	36 589
Ангара Эйрлайнс	Эрхүү	-	3 142
Захиалгат	Захиалгат	4 792	10 343
НИЙТ		926 738	1 020 891

Агаарын тээврээр олон улсад нийт 1 020,89 мян.хүн зорчсон бөгөөд үүнээс дотоодын 3 агаарын тээвэрлэгч “МИАТ” ХК 514,6 мян.хүн, “Хүннү Эйр” ХХК 44 мян.хүн, “Аэромонголиа” ХХК 24,6 мян.хүн зорчигч тус тус тээвэрлэсэн. Гадаадын 6 агаарын тээвэрлэгч “Кореан Эйр” 188,6 мян.хүн, “Эйр Чайна” 101,8 мян.хүн, “Аэрофлот” 55,1 мян.хүн, “Туркиш Эйрлайнс” 42 мян.хүн, “Эйр Бусан” 36,6 мян.хүн, “Ангара Эйрлайнс” 3,1 мян.хүн, захиалгат нислэгээр 10,3 мян.хүн зорчигчийг нийт 18 чиглэлд тус тус тээвэрлэсэн байна /Хүснэгт 3/.

Монгол Улсын агаарын зайд 2018 онд нийт 138 195 нислэг үйлдэгдсэн нь өмнөх оныхоос 13 646 нислэг буюу 11%-иар өссөн байна. Үүнээс 123 296 нислэг нь олон улсын өнгөрөлтийн нислэг бөгөөд өмнөх оныхоос 12 343 буюу 11,1%-иар өссөн нь нийт нислэгийн 89%-ийг, харин хөөрөлт, буултын тоо 14 899 байгаа нь нийт нислэгийн 11%-ийг эзэлж байна. 2018 онд олон улсын хөөрөлт, буултын тоо 8505 байсан нь өмнөх оныхоос 584 буюу 7,4%, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 6 394 байсан нь өмнөх оныхоос 719 буюу 12,7%-иар тус тус өссөн байна. /График 29/.




График 29. Нислэгийн тоо

Агаарын тээврийн салбарын орлого 2018 онд 442,2 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 56,7 тэрбум төгрөг буюу 14,7%-иар өссөн байна /График 30/.





График 30. Агаарын тээврийн орлого, тэрбум төгрөг

зорчигч урсгал



ачаа тээвэр



шуудан



Олон улсын өнгөрөлтийн нислэг
123296

Олон улсын хөөрөлт,
буултын нислэг
8505

Орон нутгийн хөөрөлт,
буултын нислэг
6394

* ИНЕГ-ын 2018 оны тайлан, мэдээ

7. УСАН ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ*

2018 онд усан замын тээврээр 25 638 хүн зорчиж, зорчигч эргэлт 0,4 сая хүн км болж, өмнөх оныхоос зорчигчийн тоо 5 082 хүн буюу 24.7%-иар өссөн байна. /График 31/

Усан замын тээврээр 1990 онд 71,6 мян.тн ачаа тээвэрлэж байсан бол 2006-2018 онд ачаа тээвэрлээгүй байна.

Усан замын тээврийн орлого 2018 онд 566,3 сая төг болж, өмнөх оныхоос 86,7%-иар өссөн үзүүлэлттэй байна.




График 31. Усан замын тээврээр зорчсон зорчигчдын тоо, мян.хүн

2018 онд зохион байгуулсан техникийн хяналтын үзлэгт нийт 129 тээврийн хэрэгсэл хамрагдахаас 124 нь хамрагдсан бөгөөд 85 тэнцэж, 19 тэнцээгүй, засвар хийгдэж байгаагийн улмаас хөвөлтөд гарах боломжгүй 20 тээврийн хэрэгсэл байсан бөгөөд бусад шалтгаанаар 5 тээврийн хэрэгсэл үзлэгт хамрагдаагүй байна.

Нийт усан замын тээврийн хэрэгслийн 75,97 хувь буюу 98 тээврийн хэрэгсэл нь Хөвсгөл аймагт, Архангай аймагт 12, Булган 4, Сэлэнгэ 3, Увс аймагт 3, Ховд аймагт 1, Баян-Өлгий аймагт 2, Дорнод аймагт 4, нийслэлд 2 тээврийн хэрэгсэл тус тус бүртгэгдсэн байна /Хүснэгт 4/.

Хүснэгт 4.

Бүртгэлтэй усан замын тээврийн хэрэгсэл, аймгаар**

Хөвсгөл			Архангай			Увс	Ховд	Баян-Өлгий	Булган	Сэлэнгэ	Дорнод	Нийслэл
Хөвсгөл нуур	Олон голын бэлчир	Эг үүрийн голуудын сав газар	Тэрхийн цагаан нуур	Өгий нуур	Чулуутын гол	Хяргас нуур	Хар ус нуур	Толбо нуур	Тишэг	Сэлэнгэ мөрөн	Буйр нуур	-
91	2	5	1	7	4	3	1	2	4	3	4	2
Нийт-129												

* МУ-ын Далайн Захиргааны мэдээлэл

** 2018 оны техникийн хяналтын үзлэг, тооллогын тайлан

2018 оны 12 дугаар сарын байдлаар 17 тээврийн хэрэгслийг шинээр бүртгэж гэрчилгээ, улсын дугаар олгосон бөгөөд бүртгэлээс 7 тээврийн хэрэгслийг хасч, гэрчилгээг хүчингүйд тооцсон байна.

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 28 улсын 316 хөлөг онгоц бүртгэлтэй их далайд үйл ажиллагаа явуулж байна. Монголын Улсын далбаатай хөлөг онгоцыг эзэмшигч улсын харьяаллыг хүснэгтээр үзүүлэв /Хүснэгт 5/.

Хүснэгт 5.

Монголын Улсын далбаатай хөлөг онгоцыг эзэмшигч улс*

№	Улс	Хөлөг онгоцны тоо	Хувиар /%/
1	Singapore	104	32.91
2	Malaysia	49	15.51
3	Republic of Panama	23	7.28
4	Hong Kong	18	5.70
5	Japan	15	4.75
6	Belize	13	4.11
7	Vietnam	13	4.11
8	Indonesia	11	3.48
9	China	10	3.16
10	Marshall Islands	8	2.53
11	Seychelles	7	2.22
12	Taiwan	7	2.22
13	United Arab Emirates	6	1.90
14	United Kingdom	6	1.90
15	Malta	5	1.58
16	British Virgin Islands	4	1.27
17	Philippines	4	1.27
18	India	2	0.63
19	Suriname	2	0.63
20	Mauritius	1	0.32
21	Myanmar	1	0.32
22	Nevis	1	0.32
23	Qatar	1	0.32
24	Samoa	1	0.32
25	Spain	1	0.32
26	St Vincent & The Grenadines	1	0.32
27	Turkey	1	0.32
28	Tuvalu	1	0.32
29	Бусад	13	4.11
Нийт		316	100

ДОТООДЫН УСАН ЗАМЫН ТЭЭВЭР



МОНГОЛ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭГДСЭН ХӨЛӨГ ОНГОЦ /ОРНООР/



* МУ-ын Далайн захиргааны тайлан, мэдээ

8. ЗАМ, ТЭЭВРИЙН ОСЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ*

Улсын хэмжээнд 2018 онд зам, тээврийн ослын шинжтэй 81 211 дуудлага хүлээн авч, 29 474 зам, тээврийн осол бүртгэн шалгасан байна. Харин 2017 онд 92 261 дуудлага хүлээн авч байсан бол 2018 онд өмнөх оныхоос 11 050 буюу 12%-иар буурсан үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд ирүүлсэн дуудлагын 95,2 хувийг нийслэл Улаанбаатар хотод ирсэн байна. /Хүснэгт 6/

Хүснэгт 6.

Зам, тээврийн ослын шинжтэй дуудлага

Он	Улсын хэмжээнд ирүүлсэн дуудлагын тоо	Нийслэлд ирүүлсэн дуудлагын тоо	Орон нутагт ирүүлсэн дуудлагын тоо
2017	92 261	88 240	4 021
2018	81 211	77 306	3 905

Монгол Улсын хэмжээнд 2018 онд 29 474 зам, тээврийн осол бүртгэгдсэний 25 666 буюу 87,0% нь нийслэл Улаанбаатар хотод, 3 808 буюу 13% нь орон нутагт бүртгэгджээ. /График 32/



График 32. Зам, тээврийн осол

Нийслэлд бүртгэгдсэн зам, тээврийн ослын 22.8 хувь нь Баянзүрх дүүрэгт, 21,5 хувь нь Баянгол, 17,8 хувь нь Сонгинохайрхан, 14,3 хувь нь Хан-Уул, 13,0 хувь нь Сүхбаатар, 9,7 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 0,8 хувь нь бусад алслагдсан 3 дүүрэгт бүртгэгджээ. /График 33/




График 33. Нийслэлд бүртгэгдсэн зам, тээврийн осол

* “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Цагаан ном 2018” эмхтгэлийн мэдээлэл




График 34. Орон нутагт бүртгэгдсэн зам, тээврийн осол, аймгаар

Орон нутагт бүртгэгдсэн зам, тээврийн ослын хамгийн өндөр хувийг 504 буюу 13%-ийг Өмнөговь, 449 буюу 12%-ийг Төв, 353 буюу 9,3%-ийг Дархан-Уул тус тус эзэлж байна. /График 34/

Зам, тээврийн ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирохоос гадна эд хөрөнгө, материалын хохирол учирдаг. 2018 онд зам, тээврийн осолд нийт 5 323 хүн өртсөнөөс 4 761 хүн гэмтэж, 504 хүн амь насаа алдсан байна. /Хүснэгт 7/

Хүснэгт 7.

Зам, тээврийн ослын улмаас амь насаа алдсан, гэмтсэн хүн, учирсан хохирол

Он	Зам, тээврийн осол		Зам, тээврийн ослоос хохирсон хүн					
			Осолд өртсөн		Амь насаа алдсан		Гэмтсэн	
	Улсын хэмжээнд	Нийслэлд	Улсын хэмжээнд	Нийслэлд	Улсын хэмжээнд	Нийслэлд	Улсын хэмжээнд	Нийслэлд
2018	28 259	25 666	5 323	3 901	504	140	4 761	3 761

2018 онд Монгол Улсын хэмжээнд 36 220 гэмт хэргийн улмаас 934 хүн нас барсны 34.7 хувь нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас амь насаа алджээ.

Зам, тээврийн ослын улмаас 2018 онд амь насаа алдсан хүний тоог өнгөрсөн оныхтой харьцуулахад улсын хэмжээнд 10,8 хувиар өсч, нийслэлийн хэмжээнд 25,0, орон нутагт 6,8 хувийн өсөлттэй байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн 29 474 зам, тээврийн ослын 28 794 буюу 97.7 хувь нь жолоочийн буруугаас, 632 буюу 2.1 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 48 буюу 0.2 хувь нь замын нөхцлөөс шалтгаалсан байна. /Хүснэгт 8/

Хүснэгт 8.

Зам, тээврийн ослын шалтгаан

Он	Жолоочийн буруу		Явган зорчигчийн буруу		Замын нөхцөл	
	Улсын хэмжээнд	Нийслэлд	Улсын хэмжээнд	Нийслэлд	Улсын хэмжээнд	Нийслэлд
2018	28794	25093	632	549	48	24
Нийт осолд эзлэх хувь	97.7	97.8	2.1	2.1	0.2	0.1

Бүртгэгдсэн зам, тээврийн ослын 97.7 хувь нь жолоочийн буруутай үйлдэл буюу хууль, дүрэм зөрчсөн, сахилга хариуцлагагүй үйл ажиллагаатай холбоотой байна.

Өнгөрсөн онд бүртгэгдсэн зам, тээврийн ослын шалтгаан, нөхцлийн өөрчлөлтийг авч үзвэл жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол 4,4 хувийн өсөлттэй, явган зорчигчийн буруутай үйлдлээс гарсан осол 24,4 хувиар, замын нөхцлөөс шалтгаалсан осол 22,4 хувиар тус тус буурсан байна.

Улсын хэмжээнд 2018 онд зам, тээврийн осол 19,5 хувиар буурчээ. Зам, тээврийн ослын шалтгаан, нөхцлийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулан судлаж үзэхэд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос шалтгаалсан осол 0,8 хувиар, хурд хэтрүүлснээс шалтгаалсан осол 49,8 хувиар, гадны гэрлийн нөлөөллөөс шалтгаалан 5 дахин, явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцсоноос осолд өртсөн тохиолдол 8.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 9.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам, тээврийн осол, төрлөөр

Төрөл	Онхолдох	Тээврийн хэрэгсэл тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх	Тээврийн хэрэгслээр явган хүн дайрсан	Тээврийн хэрэгслээр дугуйтай хүн дайрсан	Тээврийн хэрэгслээр үл хөдлөх зүйл мөргөсөн	Зорчигч унагасан	Мал амьтан дайрсан	Бусад	
Улсын хэмжээнд									
2018	тоо	805	25 176	2 519	123	648	16	93	94
	эзлэх хувь	2.7	85.4	8.5	0.4	2.2	0.1	0.3	0.3
Нийслэлд									
2018	тоо	149	22 538	2 297	108	526	7	31	10
	эзлэх хувь	0.6	87.8	8.9	0.4	2.0	0.0	0.1	0.0

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам, тээврийн ослын 25 176 буюу 85.4% нь мөргөлдөх, 2 519 буюу 8.5 % нь явган зорчигч мөргөх, 805 буюу 2.7% нь онхолдох, 648 буюу 2.2% үл хөдлөх зүйл мөргөх /хашаа, хайс, гэр, шон мөргөсөн/ 16 осол зорчигч унагах, 123 тохиолдолд унадаг дугуйтай хүн мөргөх, 93 осол мал, амьтан дайрах, 94 осол бусад хэлбэрийн төрөлд хамаарч байна. /Хүснэгт 9/

Нийт зам, тээврийн 940 осолд 1049 хүүхэд өртөж, 45 хүүхэд амь насаа алдаж, 1004 хүүхэд эрүүл мэндээрээ хохирсоны дотор 143 хүүхэд хүнд, хүндэвтэр гэмтэл авчээ. Улсын хэмжээний 2018 онд зам, тээврийн осолд өртсөн, хохирсон хүүхдийн статистик мэдээллийг өнгөрсөн оныхтой харьцуулахад амь насаа алдсан хүүхэд 18.2 хувиар, гэмтсэн хүүхэд 23.1 хувиар буурчээ.

Сүүлийн 10 жилийн дунджаар 897 хүүхэд зам тээврийн осолд өртөж, тэдний 46 нь насбарж, 851 нь эрүүл мэндээрээ хохирсон байна. Эрүүл мэндээрээ хохирсон хүүхдүүдийн 22.4% нь хүндэвтэр, хүнд хэлбэрийн зэрэг тогтоолгох хэмжээнд гэмтэж бэртжээ.

9. ДҮГНЭЛТ

Зам, тээврийн салбар нь өргөн уудам нутагтай, хүн ам харьцангуй сийрэг суурьшилтай манай улсын эдийн засгийн чухал салбарын нэг юм. Монгол Улсад авто зам, автотээвэр, төмөр замын тээвэр, агаарын тээвэр болон усан замын тээвэр гэсэн үндсэн салбарууд үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсад 2018 онд нийт 69,8 сая тн ачаа тээвэрлэсэн бөгөөд үүнээс автотээвэрээр 44,1 сая тн, төмөр замын тээвэрээр 25,7 сая тн, агаарын тээвэрээр 5,75 мянган тн ачаа тус тус тээвэрлэсэн байна. Ачаа тээвэрлэлт өмнөх онтой харьцуулахад 15,9 сая тн буюу 29,4%-иар өссөн ба үүнээс автотээвэр 4%, төмөр зам 13,2%, агаарын тээвэрлэлт 7,1% өссөн нь 1925 оноос хойш хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Үүнээс үзэхэд ачаа тээвэрлэлтийн хэмжээ цаашид өсөх хандлагатай байна.

Давхардсан тоогоор 2018 онд 200,9 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 15,19 сая хүн зорчигч буюу 7%-иар буурсан байна. Үүнээс автотээвэрээр 196,9 сая хүн, төмөр замын тээвэрээр 2,57 сая хүн, агаарын тээвэрээр 1,42 сая хүн, усан замын тээвэрээр 25,6 мянган хүн зорчигч тус тус тээвэрлэсэн байна. Автотээврийн зорчигч тээвэрлэлт өмнөх оныхоос 7,3%-иар буурсан нь салбарын нийт зорчигч тээвэрлэлтийн үзүүлэлт буурахад ихээхэн нөлөөлж байна. Буурсан шалтгааныг авч үзвэл 2015 оноос нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээ цахим төлбөрийн системд шилжсэн бөгөөд 2017 оноос төлбөрийг зөвхөн картаар хийдэг болсноор зорчигчид картаа тэр бүр цэнэглүүлэхгүй, бэлэн мөнгөөр зорчиж байгаа болон бусад зөрчлийн улмаас бүртгэгдэхгүй байгаа зэрэг шалтгаан нь салбарын нийт зорчигч тээвэрлэлт буурахад нөлөөлсөн гэж үзэж байна. Энэхүү зөрчлийг бууруулах, илрүүлсэн зөрчил бүрд холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байгаа юм.

Салбарын хэмжээнд 2018 онд нийт 1 687 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлснээс автотээврийн салбар 627,83 тэрбум төгрөг, төмөр замын салбар 616,48 тэрбум төгрөг, агаарын тээврийн салбар 422,2 тэрбум төгрөг, усан замын тээвэр 0,5 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Монгол Улсад чанартай, хүртээмжтэй авто замын сүлжээг бий болгохоор сүүлийн жилүүдэд гадаадын зээл, тусламж, улсын төсөв, төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажлууд эрчимтэй явуулснаар улсын хэмжээнд авто замын сүлжээний нийт урт 2018 оны байдлаар 111,9 мянган км болсон байна. Үүнээс 14 918,7 км нь улсын чанартай, 96 125,3 км нь орон нутгийн чанартай авто замд хамаарч байна. Улсын чанартай авто замын 6 718 км нь хатуу хучилттай, 7 065,1 км нь ердийн хөрсөн, 923,56 хайрган хучилттай, 211,9 км нь сайжруулсан хөрсөн авто зам байна.

Уул уурхайн томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан экспортын бүтээгдэхүүн жил бүр нэмэгдэж байгаа нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангахад чухал ач холбогдолтой байна. Энэ нь тээврийн салбарын Улсын эдийн засагт оруулах хувь нэмрийг өсгөж байгаа билээ.

Монгол Улсын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар 970,8 мянган тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байна. Эдгээр тээврийн хэрэгслээс техникийн хяналтын үзлэгт 634,7 мянга буюу 65,3% нь хамрагдсан байна. Үүнээс үзэхэд нийт хүн амын 5 хүн тутамд 1 тээврийн хэрэгсэл ногдож байна. Импортоор 64 039

суудлын автомашин оруулж ирсэн нь сүүлийн жилүүдийнхээс хамгийн өндөр үзүүлэлт болж байгаа бөгөөд энэ нь тээврийн хэрэгслийн тоог хурдацтайгаар өсөхөд нөлөөлж байна.

Улсын хэмжээнд 2018 онд зам, тээврийн ослын шинжтэй 81 211 дуудлага бүртгэгдсэнээс зам тээврийн осол 29 474 байна. Зам, тээврийн ослын 25 666 буюу 87,0 хувь нь нийслэл Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Ослын шинжтэй дуудлага өмнөх оныхоос 12%-иар, зам, тээврийн осол 20%-иар тус тус буурсан байна. Зам тээврийн ослын улмаас 5 323 хүн амь нас, эрүүл мэндээрээ хохирсноос 504 хүн нас барсан мэдээ байна. Амь нас, эрүүл мэндээрээ хохирсон хүний 1 049 буюу 19,7% нь хүүхэд байгаа бөгөөд үүнээс 45 хүүхэд буюу 4,3% нь нас барсан байна.

Зам, тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, осол гэмтэл түүний үр дагаврыг бууруулах тодорхой үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж үр нөлөөг тооцох нь чухал байдаг. Энэ үйл ажиллагаанд хурд хэтрүүлэх болон согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохыг бууруулах, мотоциклын хамгаалалтын малгай, суудлын даруулга, хүүхдийн хамгаалах хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээг тогтмол авч ажиллах шаардлагатай болохыг статистик мэдээллийн дүн харуулж байна.

Энэ мэтчилэн зам, тээврийн салбарын статистик мэдээлэлд үндэслэн бодлогын тодорхой дүгнэлт хийх, бодлого боловсруулах, төлөвлөхөд чухал ач холбогдолтой нь харагдаж байна.

10. ХАВСРАЛТ*

Хүснэгт 10.

Сайжруулсан авто замын урт, км

Он	Хатуу хучилттай	Хайрган хучилттай	Сайжруулсан хөрсөн зам	Нийт сайжруулсан авто зам
1950	182,0			1 029,0
1960	253,6			1 901,1
1970	387,0			2 826,5
1980	712,2			3 341,4
1985	920,6			3 613,4
1986	966,0			3 680,0
1987	1 006,7			3 729,6
1988	1 093,5			3 949,5
1989	1 184,6			4 249,7
1990	1 243,0			4 316,7
1991	1 294,0			4367,9
1992	1 303,0			3 076,0
1993	1 308,3			3 100,7
1994	1 359,3			3 162,7
1995	1 413,4			3 222,7
1996	1 471,4			3 325,1
1997	1 519,3			3 350,1
1998	1 531,7			3 351,3
1999	1 563,3			3 387,6
2000	1 567,4	938,43	947,67	3 453,5
2001	1 572,7	1 943,3	1 923,6	3 522,7
2002	1 801,9	1 871,3	1 873,6	3 673,2
2003	1 900,7	1 892,57	1 873,6	5 666,9
2004	1 900,7	1 937,8	1 844,8	5 683,3
2005	2 278,6	1 980,3	1 867,8	6 126,7
2006	2 392,8	1 980,27	1 907,8	6 280,8
2007	2 597,2	1 961,96	1 902	6 461,2
2008	2 671,2	1 999,81	1 874	6 545,0
2009	2 824,0	1 994,3	1 874	6 692,3
2010	3 015,6	2 071,58	1 647,2	6 734,4
2011	4 063,4	1 959,23	1 610,75	7 633,4
2012	4 082,9	1 959,23	1 610,75	7 652,9
2013	5 838,2	1 864,81	1 172,6	8 875,6
2014	5 838,2	1 782,5	1 184,7	8 875,6
2015	7 125,3	1 715,62	971,2	9 812,1
2016	7 456,61	1 696,82	972,6	10 126,0
2017	8 431,4	1308,9	614,9	10 355,2
2018**	9 022,7	1207,9	604,9	10 835,8

* ҮСХ-ны мэдээллийн эх үүсвэр

Зорчигч тээвэрлэлт, сая хүн*

Он	Нийт	Тээврийн төрөл			
		Төмөр замын тээвэр	Авто тээвэр	Агаарын тээвэр	Усан зам
1940	0,9	-	0,9	-	-
1950	0,9	-	0,9	-	-
1960	18,1	0,4	17,6	0,1	-
1970	53,4	0,7	52,4	0,2	-
1980	122,1	1,4	120,2	0,5	-
1986	183,9	2,4	180,9	0,6	-
1987	197,3	2,5	194,1	0,7	-
1988	234,5	2,6	231,1	0,8	-
1989	242,2	2,7	238,7	0,8	-
1990	232,2	2,6	228,8	0,8	-
1991	234,4	2,5	231,3	0,6	-
1992	252,2	2,6	249,3	0,3	-
1993	191,8	2,3	189,3	0,2	-
1994	146,8	2,9	143,7	0,2	-
1995	110,3	2,9	107,2	0,2	-
1996	109,1	3,0	105,9	0,2	-
1997	80,8	3,7	76,8	0,3	-
1998	81,5	3,9	77,3	0,3	-
1999	87,6	4,1	83,3	0,2	-
2000	93,0	4,3	88,4	0,3	-
2001	98,5	4,1	94,1	0,3	-
2002	105,7	4,0	101,4	0,3	-
2003	167,9	3,9	163,7	0,3	-
2004	194,2	4,3	189,6	0,3	-
2005	192,8	4,2	188,2	0,3	-
2006	195,4	4,3	190,7	0,555**	-
2007	209,9	4,5	205,0	0,608**	-
2008	231,6	4,3	226,9	0,606**	-
2009	232,5	3,1	229,0	0,538**	0
2010	250,7	3,5	246,7	0,67**	0,01
2011	296,2	3,8	291,8	0,892**	0,01
2012	317,97	4,0	313,16	1,098**	0,04
2013	307,94	3,8	303,38	1,106**	0,03
2014	344,18	3,31	340,15	1,019**	0,04
2015	260,0	2,8	256,5	0,955**	0,05
2016	264,0	2,6	260,7	1,023**	0,03
2017	215,7	2,6	212,2	1,251**	0,02
2018	200,42	2,57	196,9	1,422**	0,01

* ҮСХ-ны мэдээллийн эх үүсвэр

** ИНЕГ-ын мэдээлэл

Ачаа тээвэрлэлт, мян.тн*

Он	Нийт	Тээврийн төрөл			
		Төмөр замын тээвэр	Авто тээвэр	Агаарын тээвэр	Усан замын тээвэр
1925	0,4	0,0	0,4	0,0	0,0
1930	4,9	0,0	4,9	0,0	0,0
1935	69,8	0,0	69,8	0,0	0,0
1940	38,0	0,0	38,0	0,0	0,0
1942	165,4	148,8	16,6	0,0	0,0
1945	216,1	191,0	25,1	0,0	0,0
1950	323,1	270,0	53,1	0,0	0,0
1953	765,6	678,0	73,8	0,0	13,8
1955	1 282,2	1 119,9	146,1	0,0	16,2
1960	8 037,5	3 913,2	4 102,9	0,7	20,7
1965	11 294,9	2 375,0	8 894,7	1,8	23,4
1970	14 465,5	4 724,6	9 710,7	2,8	27,4
1975	20 911,0	6 861,7	13 995,7	5,1	48,5
1980	33 149,0	9 800,0	23 300,0	9,0	40,0
1985	50 950,0	15 000,0	35 900,0	10,0	40,0
1988	63 658,0	17 800,0	45 800,0	14,0	44,0
1990	54 038,5	14 517,1	39 438,9	10,9	71,6
1995	8 950,8	7 298,0	1 648,5	2,7	1,6
1996	9 451,8	7 466,0	1 982,0	2,7	1,1
1997	8 436,5	7 309,7	1 121,4	3,8	1,6
1998	8 867,3	7 615,1	1 247,4	3,5	1,3
1999	9 534,0	8 199,3	1 330,4	2,8	1,5
2000	10 643,4	9 158,5	1 480,4	2,9	1,6
2001	11 810,5	10 147,7	1 658,2	2,9	1,7
2002	13 529,9	11 637,0	1 888,7	2,4	1,8
2003	17 622,8	12 284,7	5 335,9	2,2	0,0
2004	21 596,0	14 031,8	7 561,9	2,3	0,0
2005	23 670,5	15 586,3	8 081,7	2,0	0,5
2006	23 971,38	14 779,8	9 189,4	3,3**	-
2007	23 281,62	14 072,6	9 207,1	3,6**	-
2008	23 904,43	14 646,9	9 255,7	4,1**	-
2009	24 736,7	14 164,5	10 563,8	3,5**	-
2010	29 415,91	16 804,0	12 610,2	4,5**	-
2011	44 085,95	18 447,74	25 635,28	6,2**	-
2012	50 644,29	20 445,19	30 195,09	6,6**	-
2013	42 361,41	21 035,5	21 321,86	6,5**	-
2014	44 636,18	21 118,59	23 514,15	5,5**	-
2015	32 197,3	19 150,8	13 043,7	4,7**	-
2016	40 398,4	19 989,14	20 406,17	4,85**	-
2017	53 981,08	22 765,1	31 212,9	5,37**	-
2018	69 838,7	25 763,3	44 138,9	5,75**	-

* ҮСХ-ны мэдээллийн эх үүсвэр

** ИНЕГ-ын мэдээлэл

Хүснэгт 13.

Тээврийн нийт орлого, тэрбум төгрөг*

Он	Нийт	Тээврийн төрөл			
		Төмөр замын тээвэр	Авто тээвэр	Агаарын тээвэр	Усан замын тээвэр
1993	19,97	9,68	5,72	4,57	-
1994	27,03	13,5	6,18	7,35	-
1995	36,04	16,05	8,52	11,45	0,01
1996	44,07	20,73	10,23	13,1	0,01
1997	64,98	27,33	12,95	24,68	0,01
1998	70,6	32,41	12,81	25,37	0,01
1999	79,5	35,79	13,16	30,53	0,01
2000	102	47,8	14,5	39,7	0,02
2001	120,8	63,21	15,97	41,64	0,02
2002	152,8	86,64	17,8	48,38	0,02
2003	193,7	109,9	32,7	51,09	0,02
2004	242,6	135	44,12	63,5	0,02
2005	309,5	193,6	44,25	71,63	0,02
2006	311,8	182,61	46,13	83,09	0,02
2007	342,3	173,33	76,1	92,82	0,02
2008	419,2	204,89	100,1	114,14	0,07
2009	465,6	226,42	128,46	110,7	0,03
2010	593,6	306,92	172,19	144,48	0,01
2011	854,8	390,89	299,31	164,46	0,13
2012	1 041,2	416,52	417,55	206,91	0,16
2013	1 045	421,42	376,15	247,29	0,15
2014	1 038,3	427,86	363,75	246,2	0,53
2015	987,9	387,94	345,05	254,34	0,58
2016	1 191,5	441,8	467,17	287,28	0,23
2017	1 422,3	530,02	506,43	385,53	0,3
2018	1 687	616,48	627,8	442,2	0,5

Хүснэгт 14.

Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо**

Он	Нийт тээврийн хэрэгсэлийн тоо	Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгсэл	
		Тоо	Хувь
2012	608 255	386 369	63,5%
2013	673 106	427 711	63,5%
2014	739 589	477 199	64,5%
2015	789 720	476 047	60,2%
2016	841 552	511 911	60,8%
2017	900 125	551 537	61,2%
2018	970 815	634 669	65,3%

* ҮСХ-ны мэдээллийн эх үүсвэр

** "АТҮТ" ТӨҮГ-ын VRS автотээврийн хэрэгслийн бүртгэлийн системийн мэдээлэл

11. ҮГИЙН ТАЙЛБАР

АЗБХЗГ - Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

БТГ - Бодлого, төлөвлөлтийн газар

ИНЕГ - Иргэний нисэхийн ерөнхий газар

“УБТЗ” ХНН – “Улаанбаатар төмөр зам” Хувь нийлүүлсэн нийгэмлэг

ҮСХ - Үндэсний статистикийн газар

ТЗДТБХЗГ - Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

VRS - “АТҮТ” ТӨҮГ-ын Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн систем

мян.тн - мянган тонн

тн - тонн

ш - ширхэг

км - километр

у.м - урт метр

мян.хүн - мянган хүн

тн.км - тонн километр

төг - төгрөг

мян.төг - мянган төгрөг

км хавтгай дөрвөлжин – хавтгай дөрвөлжин километр (км²)

см³-сантиметр куб

Ачаа эргэлт- Тээвэрлэсэн ачааг тээсэн зай /км/-аар үржүүлсэн үржвэрийн нийлбэрээр тооцно.

Зорчигч эргэлт- Зорчсон зорчигчдын тоог аялсан зай /км/-аар үржүүлсэн үржвэрийн нийлбэрээр тооцно.

Хянасан: БТГ-ын даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч Ж.Сэрээтэр

Боловсруулсан: БТГ-ын мэргэжилтэн
Ц.Нэмэхжаргал